

Бүгд Найрамдах Монгол Ард Улс,
Их Британи ба Умард Ирландын Нэгдсэн
Вант Улсын хоорондын Консулын конвенц

Байгуулсан огноо : 1975.11.21

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛС, ИХ БРИТАНИ
БА УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ВАНТ УЛСЫН
ХООРОНДЫН КОНСУЛЫН
КОНВЕНЦ**

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Их Британи ба Умард Ирландын Нэгдсэн Вант Улс болон түүний эзэмшил, газар нутгийн цог жавхланта хатан хаан, хамтын нөхөрлөлийн тэргүүн,

Тус хоёр улсын хоорондын найрсаг харилцааг цаашид бататгахыг эрмэлзэж,

Консулын салбарт харилцаагаа зохицуулж, өөрсдийн улс болон иргэдийн эрх ашгийг хамгаалах явдлыг хөнгөвчлөхийг хүсч,

Энэхүү Консулын конвенцийг байгуулахаар шийдвэрлэж, энэ зорилгоор өөрсдийн бүрэн эрхт төлөөлөгчдөөр:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад явдлын Яамны орлогч сайд Дүгэрсүрэнгийн Эрдэмбилэг;

Их Британи ба Умард Ирландын Нэгдсэн Вант Улс болон түүний эзэмшил, газар нутгийн цог жавхланта хатан хаан, хамтын нөхөрлөлийн тэргүүн:

Их Британи ба Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын өмнөөс:

Гадаад явдал, хамтын нөхөрлөлийн хэрэг эрхэлсэн Яамны Парламентийн орлогч сайд Каэрнарвон, Огвены барон гүн хүндэтгэлт Горонви-Робертс

нарыг тус тус томилсонд тэд зохих хэлбэр, журмын дагуу үйлдсэн бүрэн эрхийнхээ үнэмлэхийг харилцан солилцоод дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

I ХЭСЭГ

Тодорхойлолт

1-р зүйл

Энэхүү Конвенцид гарах нэр томъёог дараах утгаар ойлгоно:

- а) «консулын газар» гэж ерөнхий консулын газар, консулын газар, дэд консулын газар, консулын төлөөлөгчийн газрыг тус тус хэлнэ;
- б) «консулын тойрог» гэж консулын газрын үйл ажиллагааг явуулахад зориулан тогтоосон нутаг дэвсгэрийг хэлнэ;
- в) «консулын албан тушаалтан» гэж консулын газрын тэргүүнийг оролцуулан консулын газарт энэхүү Конвенцийн дагуу консулын үүрэг гүйцэтгэхээр томилогдсон хүнийг хэлнэ;
- г) «консулын газрын ажилтан» гэж томилогч улсаас тохоон томилогдсон бөгөөд консулын албан тушаалтан биш, энэ Конвенцийн 5-р зүйлийн дагуу хүлээн авагч улсад мэдэгдсэн
 1. захиргаа, техникийн ажилтан буюу
 2. үйлчлэгч хүнийг тус тус хэлнэ.
- д) «консулын архив» гэж албаны бүх захидал харилцаа, баримт бичиг, ажил хэрэгт холбогдох тоног төхөөрөмж, тэдгээрийг хамгаалах болон хадгалахад зориулсан тавилга төхөөрөмжийг хэлнэ;
- е) «томилогч улсын хөлөг онгоц» гэж томилогч улсын усан боомтод бүртгэлтэй хөлөг онгоцыг хэлнэ. Цэргийн хөлөг онгоц үүнд хамаарагдахгүй;
- ж) «иргэн» гэж томилогч улс хууль тогтоомжийнхоо дагуу өөрийн иргэн гэж үзэж байгаа хүмүүс болон утгаараа тохирч байвал хуулийн этгээдийг нэгэн адил хэлнэ.

II ХЭСЭГ

Консулын газрыг байгуулах, консулын албан тушаалтан, ажилтны тухай

2-р зүйл

1. Томилогч улс нь хүлээн авагч улсын нутаг дэвсгэр дээр консулын газрыг хүлээн авагч улсын зөвшөөрөлтэйгээр байгуулна.

2. Консулын газрын байрлах газар, түүний зэрэг болон консулын тойргийг томилогч ба хүлээн авагч улсууд хоорондоо хэлэлцэн тохиролцох замаар тогтооно.

3-р зүйл

1. Томилогч улс нь консулын газрын тэргүүнийг томилохдоо хүлээн авагч улсын зөвшөөрлийг дипломат шугамаар урьдчилан авна.

2. Ийнхүү зөвшөөрөл авсны дараа томилогч улс нь дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан консулыг томилсон тухай патент буюу зөвшөөрөл хүссэн бичгийг хүлээн авагч улсын Гадаад явдлын Яаманд илгээнэ. Консулыг томилсон тухай патент буюу бичигт консулын газрын тэргүүний овог нэр, харьяалал, хэргэм зэрэг, консулын тойрог болон консулын газрын байрлах газрыг заана.

3. Консулын газрын тэргүүнийг томилсон тухай патент буюу бичгийг хүлээн авсны дараа хүлээн авагч улс экзекватур буюу өөр зөвшөөрлийг аль болох богино хугацаанд үнэ төлбөргүй олгоно.

4. Консулын газрын тэргүүн нь хүлээн авагч улсаас түүнд экзекватур буюу өөр зөвшөөрлийг олгомогц үүрэгт ажилдаа орж болно.

4-р зүйл

1. Томилогч улс нь консулын газрын тэргүүнээс бусад консулын албан тушаалтны овог нэр, харьяалал, хэргэм зэрэг, албан тушаалыг хүлээн авагч улсын Гадаад явдлын Яаманд дипломат шугамаар бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

2. Хүлээн авагч улс нь консулын албан тушаалтанд консулын үүргээ гүйцэтгэх эрх олгосноо нотолсон зохих баримт бичиг олгоно.

5-р зүйл

Томилогч улс нь консулын газарт ажилтнаар томилогдсон хүний овог нэр, харьяалал, албан тушаалыг хүлээн авагч улсын Гадаад явдлын Яаманд дипломат шугамаар бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

6-р зүйл

1. Консулын албан тушаалтан нь томилогч улсын иргэн байх ёстой. Консулын албан тушаалтан нь хүлээн авагч улсын иргэн буюу түүний нутаг дэвсгэр дээр байнга оршин суугч байж үл болно.

2. Консулын газрын ажилтан нь томилогч улс, хүлээн авагч улс буюу гуравдахь улсын иргэн байж болно.

7-р зүйл

Томилогч улс нь консулын албан тушаалд хүнийг томилохдоо доорхи тохиолдолд хүлээн авагч улсын зөвшөөрлийг авна. Үүнд:

- a) консулын биш хэргээр хүлээн авагч улсад орох буюу тэнд оршин суух зөвшөөрөлтэй томилогч улсын иргэнийг томилох бол; гэвч томилогч улсаас хүлээн авагч улсад суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын бүрэлдэхүүний гишүүдийн хувьд энэхүү зүйл үл хамаарна;

- б) хүлээн авагч улсын иргэн эсхүл тэнд байнга оршин суугч буюу гуравдахь улсын иргэнийг консулын газрын ажилтнаар томилох бол.

8-р зүйл

Консулын албан тушаалтан буюу ажилтныг тааламжгүй этгээд гэж үзвэл хүлээн авагч улс нь энэ тухайгаа тайлбарлахгүйгээр ямар ч үед томилогч улсад дипломат шугамаар мэдэгдэх эрхтэй. Ийм тохиолдолд томилогч улс тэр хүнийг татан дуудах буюу консулын газрын үүрэгт ажлаас халах ёстой. Хэрэв томилогч улс энэхүү үүргээ зохих хугацаанд биелүүлэхгүй бол хүлээн авагч улс нь консулын газрыг тэргүүлж байгаа консулын албан тушаалтанд олгосон экзекватур буюу өөр зөвшөөрлөө эгүүлэн авах, консулын бусад албан тушаалтан, ажилтны хувьд тэднийг консулын албан тушаалтан буюу ажилтан гэж үзэхээс татгалзах эрхтэй.

9-р зүйл

Хүлээн авагч улс нь консулын албан тушаалтныг хамгаалах, энэхүү Конвенц болон хүлээн авагч улсын хууль тогтоомжийн дагуу тэднээс эрх ямба, дархан эрх, биед халдашгүй эрхээ эдлэх, өөрийн үүрэгт ажлаа гүйцэтгэхэд нь шаардагдах бүхий л арга хэмжээг авна.

10-р зүйл

1. Хэрэв консулын газрын тэргүүн үүргээ гүйцэтгэж чадахгүй буюу түүний албан тушаал түр эзгүй байхад хүрвэл консулын газрын тэргүүний үүргийг хүлээн авагч улсад суугаа тэр консулын газрын буюу өөр консулын газрын албан тушаалтан буюу томилогч улсын дипломат төлөөлөгчийн газрын бүрэлдэхүүний гишүүдийн аль нэг нь түр гүйцэтгэж болно. Консулын газрын тэргүүний үүргийг түр гүйцэтгэгчийн овог нэрийг хүлээн авагч улсын Гадаад явдлын Яаманд аль болох богино хугацаанд мэдэгдэнэ.

2. Консулын газрын тэргүүний үүргийг түр гүйцэтгэгч нь консулын газрын тэргүүний бүхий л үүргийг гүйцэтгэх эрхтэй. Тэр нь энэхүү Конвенцийн 3-р зүйлд заасны дагуу томилогдсон томилогч улсын консулын газрын тэргүүний нэгэн адил үүрэг хүлээн, эрх ямба, дархан эрх, биед халдашгүй байх эрхийг эдлэнэ.

3. Энэхүү зүйлийн 1-д заасны дагуу консулын газарт томилогдсон дипломат төлөөлөгчийн газрын дипломат бүрэлдэхүүний гишүүн нь энэхүү Конвенцийн 40-р зүйлийн 7-д зааснаас бусад, дипломатын хувьд түүнд олгосон эрх ямба, дархан эрх, биед халдашгүй байх эрхийг хэвээр эдлэнэ.

11-р зүйл

1. Хүлээн авагч улсад суугаа томилогч улсын дипломат төлөөлөгчийн газар нь дипломат үүргээс гадна консулын үүргийг энэхүү Конвенцийн заалтыг баримтлан гүйцэтгэж болно.

2. Консулын үүрэг гүйцэтгэх дипломат төлөөлөгчийн газрын гишүүдийн овог нэрийг хүлээн авагч улсын Гадаад явдлын Яаманд мэдэгдэж байна.

3. Консулын үүрэг гүйцэтгэхээр томилогдсон дипломат төлөөлөгчийн газрын дипломат бүрэлдэхүүний гишүүн нь энэхүү конвенцийн 40-р зүйлийн 7-д зааснаас бусад, дипломатын хувьд түүнд олгосон эрх ямба, дархан эрх, биед халдашгүй байх эрхийг хэвээр эдлэнэ.

12-р зүйл

1. Томилогч улс нь консулын газар, түүний албан тушаалтан буюу томилогч улсын харьяат, консулын газрын ажилтны хэрэгцээнд зориулж хүлээн авагч улсын хууль тогтоомжоор зөвшөөрсөний дагуу газар, байшин барилга буюу түүний хэсгийг худалдан авч эзэмших буюу түрээслэн авах эрхтэй. Томилогч улс нь дээрх зорилгоор газар, байшин барилга буюу түүний хэсгийг олж авахад хүлээн авагч улс шаардлагатай үед туслалцаа үзүүлнэ.

2. Энэхүү зүйлийн 1-д дурдсан газар, байшин барилга буюу түүний хэсэг нь хүлээн авагч улсын хотын зураг төсөл, төлөвлөлтийн дагуу барилга байгууламж барих тухай аливаа хууль дүрмийг сахих явдлаас томилогч улсыг чөлөөлөх шалтгаан болохгүй.

III ХЭСЭГ

Эрх ямба, дархан эрх

13-р зүйл

1. Томилогч улс болон хүлээн авагч улсын хэл дээр бичсэн консулын газрын нэр, томилогч улсын төрийн буюу консулын сүлд бүхий хаягийг консулын газрын байр, орох хаалга буюу түүний хажууд хадаж болно.

2. Консулын газар болон консулын газрын тэргүүний өргөөнд томилогч улсын төрийн буюу консулын далбааг мандуулж болно.

3. Консулын газрын тэргүүн албан хэрэгцээндээ хэрэглэж яваа уналгад томилогч улсын төрийн зохих далбааг мандуулж болно.

14-р зүйл

1. Зөвхөн консулын газрын хэрэгцээнд ашиглаж буй газар, байшин барилга буюу түүний хэсэгт халдаж үл болно. Хүлээн авагч улсын цагдаа буюу бусад албаны хүмүүс консулын газрын тэргүүн буюу дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, эсхүл тэдний аль нэгний томилсон хүний зөвшөөрөлгүйгээр тэр газар, байшин барилга буюу түүний хэсэгт орж үл болно.

2. Энэхүү зүйлийн 1-ийн заалт нь консулын албан тушаалтны орон сууцад нэгэн адил хамаарагдана.

3. Энэхүү зүйлийн 1, 2-ын заалтууд нь 12-р зүйлийн 2-т дурдсан хүлээн авагч улсын хотын зураг төсөл, төлөвлөлтийн дагуу барилга байгууламж барих тухай аливаа хууль тогтоомжийг сахих явдлаас томилогч улсыг чөлөөлөх шалтгаан болохгүй.

15-р зүйл

1. Консулын газрын архив, баримт бичгүүд нь ямар ч үед, хаана байгааг үл харгалзан халдашгүй байна.

2. Албан бус баримт бичиг, эд юмс архивт үл хадгалагдана.

16-р зүйл

1. Консулын газар нь томилогч улсын Засгийн газар, дипломат төлөөлөгчийн болон бусад консулын газартайгаа чөлөөтэй харилцах эрхтэй. Энэ зорилгоор консулын газар нь холбооны ердийн хэрэгсэл, элч, битүүмжилсэн богц, ачаа тээш хэрэглэхээс гадна шифр хэрэглэх эрхтэй. Холбооны ердийн хэрэгслийг консулын газар нь дипломат төлөөлөгчийн газартай нэгэн адил тарифаар ашиглана.

2. Энэхүү зүйлийн 1-д заасны дагуу холбооны ердийн хэрэгслийг ашиглан харилцаж буй консулын газрын албан бичгийн харилцаа, битүүмжилсэн богц ачаа тээш нь албан ёсны шинж чанартайг тодорхойлсон үзэгдэхүйц тэмдэгтэй бол түүнд халдаж үл болох бөгөөд хүлээн авагч улс түүнийг шалгах буюу саатуулж үл болно. Дээр дурдсан консулын битүүмжилсэн богц, ачаа тээш гэдэгт гагцхүү албан бичгийн харилцаа буюу албан хэрэгцээнд хэрэглэх эд юмс багтана.

3. Консулын албаны битүүмжилсэн богц, ачаа тээш авч яваа консулын элч нь хүлээн авагч улсаас томилогч улсын дипломат элчид олгодог эрх ямба, дархан эрх, биед халдашгүй байх эрхийг эдлэнэ.

4. Хүлээн авагч улсаас зөвшөөрсөн газар зогсох хөлөг онгоц буюу буух иргэний агаарын тээврийн нисэх онгоцны даргад консулын битүүмжилсэн богц, ачаа тээшийг өгч болно. Тэр хөлөг онгоц буюу иргэний агаарын тээврийн нисэх онгоцны даргыг консулын элч гэж тооцохгүй боловч тэр хүнд даалгаж өгсөн битүүмжилсэн богц, ачаа тээшний тоог тодорхойлон албан ёсны баримт бичиг олгоно. Хүлээн авагч улсын зохих албаны хүмүүстэй ярилцаж тохиролцсоны үндсэн дээр консулын газар нь өөрийн албан тушаалтан буюу консулын ажилтнаа явуулж тэр хөлөг онгоц буюу иргэний агаарын тээврийн нисэх онгоцны даргад, дээрх битүүмжилсэн богц ачаа тээшийг шууд чөлөөтэйгээр өгөх буюу түүнээс авч болно.

17-р зүйл

1. а) Консулын албан тушаалтан нь хүлээн авагч улсын эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө. Энэхүү Конвенцийн 40-р зүйлийн 7 болон дипломат харилцааны тухай 1961 оны 4-р сарын 18-ны өдрийн Венийн Конвенцийн 31-р зүйлийн 1-ийн а, б, в, 3-т зааснаас бусад үед иргэний ба засаг захиргааны хариуцлагаас чөлөөлөгдөнө.

б) Консулын албан тушаалтны хамт амьдран суугаа түүний гэр бүлийн хүмүүс нь хүлээн авагч улсын иргэн биш буюу тэнд байнга оршин суугч биш бол энэхүү зүйлийн «а»-д заасан зүйл тэдэнд нэгэн адил хамаарагдана.

2. а) Хэрэв консулын газрын ажилтан нь хүлээн авагч улсын иргэн биш буюу тэнд байнга оршин суугч биш бөгөөд энэхүү Конвенцийн 1-р зүйлийн г-гийн 1-д хамаарагдах бол хүлээн авагч улсын эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх бөгөөд албан үүргээ гүйцэтгэж байхдаа үйлдсэн ямар ч хэргээр түүнийг иргэний ба засаг захиргааны хариуцлагад татаж үл болно.

б) Хэрэв консулын газрын ажилтны хамт амьдран суугаа гэр бүлийн хүмүүс нь хүлээн авагч улсын иргэн биш буюу тэнд байнга оршин суугч биш бөгөөд энэхүү Конвенцийн 1-р зүйлийн г-гийн 1-д хамаарагдах бол энэхүү зүйлийн «а»-гийн эхний хэсэг тэдэнд нэгэн адил хамаарагдана.

3. Хэрэв консулын газрын ажилтан нь хүлээн авагч улсын иргэн биш буюу тэнд байнга оршин суугч биш бөгөөд энэхүү Конвенцийн 1-р зүйлийн г-гийн 2-т хамаарагдах бол албан үүргээ гүйцэтгэж байхдаа үйлдсэн ямар ч хэргээр түүнийг хуулийн хариуцлагад татаж үл болно.

4. Энэхүү Конвенцийн 17, 18-р зүйлд заасан хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх дархан эрх буюу хувийн халдашгүй эрх үл эдлэх консулын газрын ажилтан, консулын албан тушаалтан буюу консулын газрын ажилтны гэр бүлийн гишүүнийг баривчлах, саатуулах буюу эсхүл түүний эсрэг эрүүгийн хэрэг сэдэхэд хүрвэл хүлээн авагч улс нь томилогч улсын консулын зохих албан тушаалтанд даруй мэдэгдэнэ.

18-р зүйл

1. Консулын албан тушаалтан хувийн халдашгүй эрх эдлэнэ. Түүнийг ямар нэг хэлбэрээр баривчлах буюу саатуулж үл болно. Хүлээн авагч улс түүнд хүндэтгэлтэйгээр халдаж амь бие, эрх чөлөө, нэр хүндэд нь ямар нэг хэлбэрээр халдах явдлаас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авна.

2. Консулын албан тушаалтны хамт амьдран суугаа бөгөөд хүлээн авагч улсын иргэн биш буюу тэнд байнга оршин суугч биш гэр бүлийн хүмүүст энэхүү зүйлийн 1-ийн заалт нэгэн адил хамаарна.

19-р зүйл

1. Консулын албан тушаалтан гэрчийн хувьд мэдүүлэг өгөх үүрэггүй. Хэрэв томилогч улс зөвшөөрвөл консулын албан тушаалтан нь шудрага ёсны үүднээс хүлээн авагч улсын хүсэлтээр гэрчийн мэдүүлэг өгч болно. Ийм тохиолдолд консулын албан тушаалтан нь албан үүрэгтэйгээ холбогдсон асуудлаар буюу томилогч улсын хууль тогтоомжийн дагуу шинжээчийн хувьд гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзаж болно.

2. Хэрэв консулын албан тушаалтан гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзлаа гэж түүнд албадлагын арга хэмжээ авах буюу хуулийн хариуцлагад татаж үл болно.

3. Энэхүү зүйлийн 1, 2-ын заалт нь Конвенцийн 1-р зүйлийн г-гийн 1-д хамаарагдах, хүлээн авагч улсын иргэн биш буюу тэнд байнга оршин суудаггүй консулын газрын ажилтан нарт нэгэн адил хамаарна.

4. Энэхүү зүйлийн заалтад үл хамаарагдах консулын газрын ажилтан албан үүрэгтэйгээ холбогдсон асуудлаар буюу томилогч улсын хууль тогтоомжийн дагуу шинжээчийн хувьд мэдүүлэг өгөхөөс татгалзаж болно.

5. Гэрчийн мэдүүлгийг хүлээн авагч улсын зөвшөөрснөөр консулын газарт буюу консулын албан тушаалтан, консулын газрын ажилтны орон сууцанд амаар буюу бичгээр авч болно. Гэрчийн мэдүүлэг авахдаа консулын газрын ажилд саад учруулахаас аль болохоор зайлсхийх бүхий л боломжтой арга хэмжээг авна.

6. Энэхүү зүйлийн заалтууд нь хүлээн авагч улсын шүүн таслах буюу засаг захиргааны байгууллагад нэгэн адил хамаарна.

7. Энэхүү зүйлийн заалтууд нь консулын албан тушаалтан буюу консулын газрын ажилтны хамт амьдран суугаа хүлээн авагч улсын иргэн биш бөгөөд тэнд байнга оршин суугч биш гэр бүлийн хүмүүст нэгэн адил хамаарна.

8. Энэхүү зүйлийн заалтууд Конвенцийн 40-р зүйлийн 7-гийн заалтыг үл хөндөнө.

20-р зүйл

1. Томилогч улс нь энэхүү Конвенцийн 17, 18, 19-р зүйлд заасан хүмүүст эрх ямба, дархан эрх, биед халдашгүй байх эрх эдлүүлэхээс хэдийд ч татгалзаж болно.

2. Энэхүү зүйлийн 3-т заасныг хөндөхгүйгээр эрх ямба, дархан эрх, биед халдашгүй байх эрхээс татгалзаж байгаагаа тодорхой илэрхийлэх ёстой бөгөөд энэ тухайгаа хүлээн авагч улсад бичгээр мэдэгдэнэ.

3. Энэхүү Конвенцийн 17-р зүйлийн дагуу хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх хүн хэрэг сэдсэн үед үндсэн нэхэмжлэлтэй нь шууд холбогдсон сөрөг нэхэмжлэл гаргахад тэр хүн хуулийн хариуцлагаас чөлөөлөгдөх дархан эрхээс иш татах эрхээ алдана.

4. Иргэний болон засаг захиргааны хэргийн талаар хариуцлагаас чөлөөлөгдөх дархан эрхээс татгалзах явдал нь шийдвэрийг биелүүлэхээс чөлөөлөгдөх дархан эрхэд үл хамаарах бөгөөд үүний тулд жич татгалзвал зохино.

21-р зүйл

1. Консулын албан тушаалтан хүлээн авагч улсын цэргийн алба хаах болон албадлагын бусад аливаа үүргээс чөлөөлөгдөнө.

2. Энэхүү зүйлийн 1-ийн заалт хүлээн авагч улсын иргэн биш консулын газрын ажилтан, консулын албан тушаалтан буюу консулын газрын ажилтны хамт амьдран суугаа гэр бүлийн хүмүүст нэгэн адил хамаарна.

22-р зүйл

1. Консулын албан тушаалтан буюу тэнд байнга оршин суугч биш консулын газрын ажилтан нь хүлээн авагч улсын хууль дүрэм, тогтоосон журмын дагуу гадаадын иргэдийг бүртгэх, оршин суух зөвшөөрөл авах шаардлагыг биелүүлэхээс чөлөөлөгдөнө.

2. Хэрэв консулын албан тушаалтан буюу ажилтны хамт амьдран суугаа гэр бүлийн хүмүүс нь тэнд байнга оршин суугч биш бол тэдэнд энэхүү зүйлийн 1-ийн заалт нэгэн адил хамаарна.

23-р зүйл

Консулын албан тушаалтны болон томилогч улсын харьяат бөгөөд хүлээн авагч улсад байнга оршин суугч биш консулын газрын ажилтны хүлээн авагч улсад консулын албан үүрэг гүйцэтгэж байх үед төрсөн хүүхдийг гагцхүү тэнд төрснөөр нь хүлээн авагч улсын иргэнд тооцож үл болно.

24-р зүйл

1. Хүлээн авагч улсаас ноогдуулах буюу хураах татвар хураамжаас доорхи зүйлүүд чөлөөлөгдөнө. Үүнд:

- а) консулын албан тушаалтан буюу консулын газрын ажилтны орон сууцыг оролцуулан гагцхүү консулын газрын хэрэгцээнд томилогч улс буюу түүний нэрийн өмнөөс ямар нэгэн иргэн, хуулийн этгээд өмчилж буюу түрээслэн ашиглаж байгаа газар, байшин барилга буюу барилгын хэсэг;
- б) энэхүү зүйлийн «а»-д дурдсан зорилгоор үл хөдлөх хөрөнгө олж авахтай холбогдуулан хийх хэлцэл буюу бусад баримт бичгүүд.

2. Энэхүү зүйлийн 1-ийн «а»-гийн заалт нь тодорхой үйлчилгээнд төлөх хөлсөнд үл хамаарна.

25-р зүйл

Томилогч улс, түүнийг төлөөлж байгаа иргэн, хуулийн этгээд нь хүлээн авагч улсын хууль тогтоомжийн дагуу хөдлөх хөрөнгөтэй болох, түүнийг өмчлөх, эзэмших буюу зарцуулахтай холбогдуулан аливаа төрлийн татвар хураамж төлөх ёстой боловч уул хөдлөх хөрөнгийг консулын газрын хэрэгцээнд ашиглавал татвар хураамж төлөхөөс чөлөөлөгдөнө.

26-р зүйл

Хүлээн авагч улс нь консулын албан тушаалтан, хүлээн авагч улсын иргэн биш консулын газрын ажилтны албан ажлаа гүйцэтгэж авах цалин хөлсөнд аливаа төрлийн татвар, хураамж оногдуулах буюу авч болохгүй.

27-р зүйл

1. Энэхүү зүйлийн 2-т заасны дагуу аливаа төрлийн татвар хураамж төлөх ёстой консулын албан тушаалтан буюу консулын газрын ажилтан нь томилогч улсын улсын байгууллагын ажилтан бөгөөд хэрэв хүлээн авагч улсын иргэн биш, хувийн ашиг сонирхлын үүднээс хүлээн авагч улсад ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй бол аливаа төрлийн татвар, хураамж оногдуулах буюу авч болохгүй.

2. Энэхүү зүйлийн 1-ийн заалт нь доорхи зүйлд үл хамаарна. Үүнд:

- a) хүлээн авагч улсын нутаг дэвсгэр дээр байгаа үл хөдлөх хөрөнгийг олж авах, эзэмших, ашиглах буюу захиран зарцуулахтай холбогдсон татвар;
- б) 26-р зүйлд дурдсанаас өөр эх булгаас орж байгаа ашиг орлоготой нь холбогдсон татвар;
- в) Хэлцэл буюу түүнтэй холбогдсон баримт бичгүүд, тэдгээрээс авах гэмдэгтийн болон бусад татвар;
- г) нас барагч нь 28-р зүйлд дурдсан хүн биш бол хөрөнгийг нь шилжүүлэх, түүнийг өв залгамжлахад холбогдох татвар.

28-р зүйл

Хэрэв хүлээн авагч улсын иргэн биш консулын албан тушаалтан буюу консулын газрын ажилтан, эсхүл түүнтэй хамт амьдран сууж байсан гэр бүлийн гишүүн хүлээн авагч улсад хөдлөх хөрөнгө үлдээн нас барж тэрхүү хөдлөх хөрөнгө нь нас барагчийг хүлээн авагч улсад консулын албан тушаалтан буюу консулын газрын ажилтнаар буюу тэдний гэр бүлийн гишүүн байсантай нь шууд холбоотой бол хүлээн авагч улсын аливаа татвар хураамжаас чөлөөлөгдөнө.

29-р зүйл

1. Консулын газрын албан хэрэгцээнд зориулан авчирч буй аливаа эд юмс, түүний дотор тээврийн хэрэгсэл нь томилогч улсын дипломат төлөөлөгчийн газрын хэрэгцээнд зориулан авчирч буй эд юмсын нэгэн адил гаалийн үзлэг, гаалийн татвар, бусад татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

2. а) Хүлээн авагч улсын иргэн биш, томилогч улсын консулын албан тушаалтан буюу консулын газрын ажилтан нь томилогч улсын улсын байгууллагын ажилтан бөгөөд хувийн ашиг сонирхлын үүднээс ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй бол хувийн хэрэгцээндээ зориулан авчирч буй авто машин болон бусад эд юмс нь томилогч улсын дипломат төлөөлөгчийн газрын зохих хэргэм зэргийн тушаалтнуудын эд юмсын нэгэн адил гаалийн хураамж, татвар буюу бусад хураамжаас чөлөөлөгдөнө.

б) Энэхүү зүйлийн «а»-гийн заалт нь хүлээн авагч улсын иргэн биш, тэнд хувийн ашиг сонирхлын үүднээс ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй консулын албан тушаалтан, консулын газрын ажилтны хамт амьдарч байгаа гэр бүлийн хүмүүст нэгэн адил хамаарна.

3. Энэхүү зүйлийн 2-ын «дипломат төлөөлөгчийн газрын зохих хэргэм зэргийн тушаалтан» гэж консулын албан тушаалтны тухайд бол дипломат ажилтнуудыг хэлэх бөгөөд консулын газрын ажилтны тухайд бол захиргаа, техникийн хүмүүсийг хэлнэ.

4. Консулын албан тушаалтан буюу түүний хамт амьдарч байгаа гэр бүлийн хүмүүсийн хувийн ачаа нь дипломат ажилтны ачааны нэгэн адил гаалийн үзлэгээс чөлөөлөгдөнө.

5. Хэлэлцэн Тохирогч Эрхэм хоёр Этгээд нь тохиромжтой гэж үзвэл энэхүү зүйлийн заалтуудыг дипломат төлөөлөгчийн газрын гишүүн биш консулын албан тушаалтан, консулын газрын ажилтнуудын хувьд хэрэглэх зорилгоор тусгай хэлэлцээр байгуулахаар хэлэлцээ хийж болно.

30-р зүйл

Консулын албан тушаалтан, консулын газрын ажилтан, тэдний хамт амьдран суугаа гэр бүлийн хүмүүс нь хүлээн авагч улсын хууль тогтоомжийн дагуу улсын аюулгүй байдлыг хангах зорилгын үүднээс зорчихыг хориглосон буюу хязгаарласнаас бусад консулын тойргийнхоо доторхи нутаг дэвсгэрээр чөлөөтэй зорчин явж болно.

31-р зүйл

Энэхүү Конвенцийн дагуу эрх ямба, дархан эрх, биед халдашгүй байх эрх эдлэх хүмүүс нь уг эрх ямбад хохирол учруулахгүйгээр гудамжны хөдөлгөөн болон автомашины даатгалын тухай хууль тогтоомжийг оролцуулан хүлээн авагч улсын хууль тогтоомжийг хүндэтгэх ёстой.

IV ХЭСЭГ

Консулын үүрэг

32-р зүйл

1. Консулын албан тушаалтан нь энэ хэсэгт заасан үүргүүдийг гүйцэтгэнэ. Түүнээс гадна хүлээн авагч улсын хууль тогтоомжид харшлахгүй бол консулын бусад үүргүүдийг гүйцэтгэж болно.

2. Консулын албан тушаалтан нь албан үүргээ гүйцэтгэхдээ:

- а) консулын тойрогтоо байгаа эрх бүхий байгууллагууд;
- б) хүлээн авагч улсын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн хэмжээгээр төвийн эрх бүхий байгууллагуудтай харилцаж болно.

3. Консулын албан тушаалтан нь гагцхүү консулын тойрогтоо консулын үүрэг гүйцэтгэнэ. Консулын тойргоосоо гадна консулын үүрэг гүйцэтгэхэд хүрвэл, хүлээн авагч улсын зөвшөөрлийг тухай бүрд нь авна.

4. Томилогч улсын консулын албан тушаалтан нь хүлээн авагч улсад мэдэгдсэн бөгөөд хүлээн авагч улс татгалзахгүй бол гуравдахь улсын өмнөөс консулын үүрэг гүйцэтгэх эрхтэй.

5. Консулын албан тушаалтан нь хүлээн авагч улсад мэдэгдсэний дараа олон улсын байгууллагад томилогч улсаа төлөөлж болно. Ингэж төлөөлөхдөө олон улсын хууль зүйгээр олгосон хөнгөлөлт, эрх ямба, дархан эрх, биед халдашгүй байх эрхүүдийг эдлэнэ.

6. Консулын албан тушаалтан нь хүлээн авагч улсад томилогч улсын хууль тогтоомжийн дагуу консулын үйл ажиллагааг явуулж зохих хураамжийг авна.

33-р зүйл

1. Консулын албан тушаалтан нь томилогч улсын иргэнтэй харилцах, уулзах, зөвлөлгөө өгөх, түүнээс хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагуудтай харилцахад нь болон шаардлагатай үед хууль эрхийн талаар тусалцаа үзүүлэх, хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагуудын хүсэлтээр буюу тэдний зөвшөөрлөөр томилогч улсын иргэнд хэлмэрчлэх буюу түүнд хэлмэрч олж өгөх эрхтэй.

2. Хүлээн авагч улс нь томилогч улсын иргэнийг консулын газартаа очих буюу түүнтэй холбоо тогтооход нь ямар нэг саад тотгор учруулж болохгүй.

34-р зүйл

Консулын албан тушаалтан нь:

- а) томилогч улс болон түүний иргэд, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах;
- б) томилогч улс ба хүлээн авагч улсын хооронд худалдаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны харилцаа болон хоёр улсын хоорондын найрсаг харилцааг цаашид хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх.

35-р зүйл

1. Консулын албан тушаалтан нь дараах эрхийг эдлэнэ:
 - а) томилогч улсын хууль тогтоомжийн дагуу харъяаллын асуудлаар гаргасан өргөдлийг хүлээн авах;
 - б) хүлээн авагч улсын нутаг дэвсгэр дээр байгаа өөрийн улсын иргэдийн бүртгэлийг хөтлөх;
 - в) тэдний төрөлт, нас баралтыг бүртгэх буюу түүний тухай мэдээ сэлт авах;
 - г) томилогч улсын хууль тогтоомжийн дагуу томилогч улсын иргэдээс гаргасан гэр бүлийн харилцааны холбогдолтой өргөдлийг хүлээн авах.
2. Энэхүү зүйлийн 1-ийн в-гийн заалт хүлээн авагч улсын хууль тогтоомжийн дагуу тэр улсын зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэх буюу бүртгүүлэх шаардлагатай бол тэр хүмүүс уг үүргээс чөлөөлөгдөхгүй.

36-р зүйл

Консулын албан тушаалтан нь паспорт, орох, гарах, дамжин өнгөрөх виз болон зам явах бусад баримт бичиг олгох, хураан авах, шинэчлэх, өөрчлөлт оруулах, хүчинтэй байх хугацааг сунгах эрхтэй.

37-р зүйл

1. Консулын албан тушаалтан нь:
 - а) дор дурдсан үед хуульчилсан акт болон хууль зүйн шинжтэй бусад баримт бичиг буюу түүний хувийг үйлдэх, гэрчлэх, нотлох, хууль ёсны болгох эрхтэй. Үүнд:
 - I. аль ч улсын иргэний хүсэлтээр томилогч улсад буюу томилогч улсын хууль тогтоомжийн дагуу хэрэглэх баримт бичиг;
 - II. томилогч улсын иргэний хүсэлтээр бусад улсад хэрэглэх баримт бичиг;
 - б) баримт бичиг орчуулах, орчуулгын үнэн зөвийг гэрчлэх эрхтэй.
2. Энэхүү зүйлийн 1-д дурдсан баримт бичгүүдийг хүлээн авагч улсын нутаг дэвсгэр дээр хэрэглэхэд хууль тогтоомжид нь харшлахгүй бол, хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагууд түүнийг хуулийн нотлох хүчинтэй гэж үзнэ.
3. Энэхүү зүйлээр консулын албан тушаалтанд олгосон эрх хүлээн авагч улсын хууль тогтоомжид харшлахгүй байвал зохино.

38-р зүйл

Томилогч улсын иргэн эзгүй байснаас буюу хүндэтгэн үзэх шалтгаанаар өөрийн ашиг сонирхлоо зохих цагт нь хамгаалж чадахгүй үед консулын албан тушаалтан буюу түүнийг төлөөлөх хүн хүлээн авагч улсын хууль тогтоомжийн дагуу түүний эрх бүхий байгууллагын өмнө төлөөлөх эрхтэй. Ийнхүү төлөөлөх нь уг иргэн өөрийгөө төлөөлөх хүнийг томилох буюу өөрөө эрх, ашиг сонирхлоо хамгаалах хүртэл үргэлжилнэ. Түүнчлэн консулын албан тушаалтан нь өөрийн иргэнтэйгээ холбогдох асуудлыг хэлэлцэх гэж байгааг түүнд мэдэгдэх буюу уг иргэн өөрөө биеэр байлцах эсхүл төлөөний хүн ирүүлэх боломжтой хугацааг хүртэл хэлэлцэх асуудлыг хойшлуулах саналыг зохих эрх бүхий байгууллагад тавьж болно.

39-р зүйл

Томилогч улсын иргэн хүлээн авагч улсын нутаг дэвсгэр дээр нас барсныг мэдмэгц хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагууд энэ тухай уг иргэнийг харьяалах улсын консулын албан тушаалтанд даруй мэдэгдэж, тэр иргэний нас барсныг нотолсон баримт бичиг болон холбогдох бусад баримт бичгийн хуулбарыг саадгүй дамжуулж өгнө.

40-р зүйл

1. а) Энэхүү зүйлийн 3-т заасны дагуу хүлээн авагч улсын нутаг дэвсгэр дээр өв хөрөнгө үлдээн нас барсан ямар нэг улсын иргэнийг төлөөлөн эрх ашгийг нь хамгаалах эрхтэй консулын албан тушаалтанд хүлээн авагч улсын зохих эрх бүхий байгууллагууд өв хөрөнгийн тухай мэдэгдэнэ;

томилогч улсын иргэн байсан хүний өв хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй хүн буюу түүнийг төлөөлөх хүн хүлээн авагч улсад байхгүй бол хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага нь томилогч улсын консулын албан тушаалтанд мөн мэдэгдэнэ.

б) Ийнхүү мэдээг ямар нэгэн өөр шугамаар хүлээн авбал консулын албан тушаалтан нь хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагад мөн нэгэн адил мэдэгдэнэ.

2. Томилогч улсын нас барсан иргэн хүлээн авагч улсад өв хөрөнгө үлдээсэн бол консулын албан тушаалтан өөрөө буюу төлөөлөх хүнээрээ дамжуулан:

- а) тэр өв хөрөнгийг хамгаалах, хадгалах;
- б) түүнийг бүрэн гүйцэд захиран зарцуулах зохих арга хэмжээ авах эрхтэй.

3. Томилогч улсын иргэн нь, аль ч улсын иргэн байсныг үл харгалзан нас барсан хүний өв хөрөнгөөс зохих хувь авах ёстой боловч хүлээн авагч улсад өөрөө буюу түүнийг төлөөлөх хүн байхгүй байвал томилогч улсын консулын албан тушаалтан нь зохих хэлбэрээр хийгдсэн итгэмжлэлийг уул иргэнээс олгосон шиг түүний эрх ашгийг төлөөлөн хамгаалах бүрэн эрхээр хангагдана.

4. а) Энэхүү зүйлийн 2 ба 3-т заасан арга хэмжээнүүдийг адил буюу илүү эрхтэй хүмүүс, эсхүл тэднийг төлөөлөх хүн аваагүй бол консулын албан тушаалтан уг арга хэмжээг авна.

б) Хэрэв хүлээн авагч улсын хууль тогтоомжийн дагуу, энэхүү зүйлийн 2 буюу 3-т заасан арга хэмжээнүүдийг авахаас өмнө тусгай төлөөлөх эрх олгосон баримт бичиг буюу шүүхийн зөвшөөрөл авах хэрэгтэй бол консулын албан тушаалтны хүсэлтээр хүлээн авагч улсын хууль тогтоомжийн дагуу түүнд уг зөвшөөрлийг олгоно. Хэрэв хүлээн авагч улсын хууль тогтоомжийн дагуу зөвшөөрлийг гагцхүү тэр иргэний нэр дээр олгох ёстой бол тийм хэлбэрээр уг зөвшөөрлийг олгох бөгөөд консулын албан тушаалтан нь түүний үндсэн дээр, энэхүү зүйлийн дагуу зохих арга хэмжээ авна.

5. Консулын албан тушаалтан нь нас барсан хүний хариуцах эзэнгүй үлдсэн өв хөрөнгийг авах эрхтэй бөгөөд өв хөрөнгийг эзэмших эрх бүхий боловч хүлээн авагч улсад байхгүй байгаа томилогч улсын иргэнийг төлөөлж хүлээн авагч улсын шүүхийн байгууллага, агент буюу төлөөлөгчөөс уг хөрөнгийг авах эрхтэй. Дээрх шүүхийн байгууллага, агент буюу төлөөлөгч нь консулын албан тушаалтнаас:

- а) түүнд зохих иргэнээс олгосон итгэмжлэх бичиг буюу бусад зөвшөөрлийг үзүүлэхийг шаардах;
- б) мөнгө буюу эд хөрөнгийг дурдсан иргэн хүлээн авсан тухай боломжтой баталгаа үзүүлэхийг шаардах;
- в) боломжтой баталгаа байхгүй бол тэр мөнгө буюу хөрөнгийг хүлээн авагч улсад эгүүлэн өгөхийг тус тус шаардаж болно.

б. а) Хэрэв хүлээн авагч улсад оршин суудаггүй томилогч улсын иргэн жуулчлах буюу дамжин өнгөрч явахдаа нас барвал, консулын албан тушаалтан түүний мөнгө болон биедээ авч явсан эд хөрөнгийг хамгаалахын тулд эл мөнгө болон эд хөрөнгийг өөрийн мэдэлд шууд авах эрхтэй.

б) Консулын албан тушаалтан нь өмч өвлөх зохих эрхийн дагуу нас барагчийн биедээ авч явсан эд юмсыг шилжүүлэн авах эрхтэй боловч мөнгө болон бусад зүйлийн хувьд хүлээн авагч улсын хуулинд өөрөөр заагаагүй бол энэхүү зүйлийн 2, 3, 4-ийн заалтыг баримтална.

7. Хэрэв консулын албан тушаалтан дээрх өв хөрөнгийг эзэмшихэд хүрвэл, 17, 18, 19-р зүйлүүдийн заалтыг харгалзахгүйгээр хүлээн авагч улсын иргэний хууль тогтоомжийн холбогдох заалтад захирагдах ёстой.

41-р зүйл

1. Консулын албан тушаалтан нь хүлээн авагч улсын шүүх буюу засаг захиргааны байгууллагад томилогч улсын иргэн, түүний ямар ч арчлалт хамгаалалтгүй байгаа өв хөрөнгийг асран хамгаалах буюу харгалзан дэмжих хүмүүсийн нэрсийг дэвшүүлэх эрхтэй.

2. Хэрэв шүүх буюу засаг захиргааны байгууллага нь нэр дэвшсэн хүнийг тохиромжгүй гэж үзвэл, консулын албан тушаалтан нь өөр хүний нэрийг дэвшүүлж болно.

42-р зүйл

1. Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагууд томилогч улсын иргэнийг барих, хорих буюу өөр ямар нэг хэлбэрээр саатуулбал энэ тухайгаа томилогч улсын консулын албан тушаалтанд нэн даруй мэдэгдэнэ. Энэ мэдэгдлийг уг иргэнийг барьсан, хорьсон буюу өөр ямар нэг хэлбэрээр саатуулсан мөчөөс хойш аль болох богино хугацаанд буюу харилцаа холбооны байдлаас шалтгаалан нэгээс гурван өдрөөс хэтрүүлэхгүй хийсэн байвал зохино.

2. а) 42-р зүйлийн 1-ийн дагуу мэдэгдсэнээс хойш, шүүхийн таслан шийтгэх ажиллагаа явагдахаас өмнө консулын албан тушаалтан нь өөрийн иргэнтэй харилцах, уулзах буюу түүнтэй ярилцах, эрхийн туслалцаа үзүүлэх, түүнийг төлөөлөх эрхийг эдлэнэ. Уг иргэнийг барьсан, хорьсон буюу өөр ямар нэг хэлбэрээр саатуулсан мөчөөс хойш аль болох богино хугацаанд буюу түүний хаана байгаагаас шалтгаалан хоёроос дөрөв хоногийн дотор уулзахыг зөвшөөрөх бөгөөд цаашид боломжтой хугацаанд үе үе уулзаж байхыг зөвшөөрнө. Уг иргэнээс консулын албан тушаалтанд дамжуулсан мэдээний эх хувийг нь хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагууд авах шаардлагатай гэж үзвэл үлдээж, хуулбарыг түүнд даруй дамжуулна.

б) Энэхүү зүйлийн «а»-гийн заалтыг нэгэнт хэргээ таслуулаад хоригдол гэж тооцогдож байгаа бөгөөд тогтоосон хугацаа хэтрээгүй үед хүлээн авагч улсын хууль тогтоомжоор давж заалдах эрхтэй томилогч улсын иргэний хувьд нэгэн адил хэрэглэнэ.

3. Томилогч улсын иргэн нэгэнт хэргээ таслуулсан буюу хоригдол гэж тооцсон бөгөөд 2-ын «б»-гийн заалтыг баримталж болохгүй тохиолдол гарвал, консулын албан тушаалтан уг иргэнтэйгээ харилцах, уулзах, түүнтэй ярилцах эрхтэй. Консулын албан тушаалтанд өөрийн тэр иргэнтэй боломжтой хугацаанд үе үе уулзах зөвшөөрөл олгож байна.

4. а) Томилогч улсын аль нэг иргэний эсрэг эрүүгийн хэрэг үүсгэх тохиолдолд уг хэргийн тухай мэдээг хүлээн авагч улсын хууль тогтоомжийн дагуу консулын албан тушаалтанд түүний хүсэлтээр мэдэгдэж байх ёстой.

б) Консулын албан тушаалтан томилогч улсын иргэний хэргийг хүлээн авагч улсад таслах үед тэр улсын хууль тогтоомжийн дагуу таслан шийтгэх хуралдаан дээр байлцах эрхтэй.

5. Энэхүү зүйлд заасан бүх мэдээлэл, яриаг консулын албан тушаалтны сонгосон ёсоор томилогч буюу хүлээн авагч улсын хэл дээр, эсвэл хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр өөр улсын хэл дээр явуулж болно.

6. Зохих байгууллагын дүрэм журамд зөвшөөрсөн хэмжээгээр консулын албан тушаалтан нь энэхүү зүйлд дурдсан өөрийн иргэнд хоол хүнс, хувцас хунар хийгээд ном, бичиг хэргийн зүйл бүхий илгээлт явуулж болно.

7. Энэхүү зүйлд дурдсан томилогч улсын хоригдож байгаа иргэнтэй харилцах, уулзах, ярилцах эрхийг хүлээн авагч улсын зохих хууль тогтоомжид харшлахгүй нөхцлийн үндсэн дээр олгоно; энэхүү хууль тогтоомж нь хоригдож байгаа иргэнтэй харилцах, уулзах, ярилцах эрхийг үгүйсгэх ёсгүй.

8. Хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагууд энэхүү зүйлийн дагуу томилогч улсын иргэнтэй харилцах, уулзах буюу түүнтэй ярилцах эрх олгосноо уг иргэнд нэн даруй мэдэгдэх ёстой.

43-р зүйл

1. Консулын албан тушаалтан нь өөрийн тойрогт байгаа усан боомт буюу зогсоолд байгаа томилогч улсын хөлөг онгоцонд бүх талын туслалцаа үзүүлнэ.

2. Томилогч улсын хөлөг онгоц хүлээн авагч улсын усан боомттой харилцахыг зөвшөөрмөгц консулын албан тушаалтан нь түүнтэй холбоо барих, түүн дээр очих эрхтэй.

3. Хөлөг онгоцны дарга буюу түүний багийн гишүүн консулын албан тушаалтантай холбоо барих эрхтэй. Тэд хүлээн авагч улсын усан боомтын район болон тэр районоор гадаадын хүмүүс зорчих тухай хууль тогтоомжид харшлахгүй бол консулын газарт хүрэлцэн очиж болно.

4. Консулын албан тушаалтан нь томилогч улсын хөлөг онгоц, түүний дарга буюу багийн гишүүдтэй холбогдон гарсан аливаа асуудлаар албан үүргээ гүйцэтгэхдээ хүлээн авагч улсын зохих эрх бүхий байгууллагаас туслалцаа хүсч болно.

44-р зүйл

1. Консулын албан тушаалтан нь доорхи эрхийг эдлэнэ. Үүнд:

- а) хүлээн авагч улсын эрхийг хөндөхгүйгээр томилогч улсын хөлөг онгоцон дээр аялалын үед гарсан будлианыг шүүх, хөлөг онгоцны баримт бичгүүдийг шалгах, хөлөг онгоцны дарга буюу багийн гишүүдийг асуух, аялал ба хөлөг онгоцны очих газрын тухай мэдээлэл авах, усан боомтод хөлөг онгоц орох, тэнд байх буюу түүнээс гарахад туслалцаа үзүүлэх;
- б) хүлээн авагч улсын хууль тогтоомжид харшлахгүй бол хөлөг онгоцны дарга буюу багийн гишүүнээр авах буюу түүнээс халахтай холбогдсон арга хэмжээ авах;
- в) хүлээн авагч улсын эрхийг хөндөхгүйгээр, хөлөг онгоцны дарга, багийн гишүүний хооронд цалин хөлс, хөдөлмөрийн гэрээний талаар гарсан маргааныг оролцуулан аливаа маргааныг томилогч улсын хууль тогтоомжид зааснаар шийдвэрлэх;

- г) хөлөг онгоцны дарга буюу багийн гишүүнийг эмнэлэгт хэвтүүлж эмчлүүлэх болон эх оронд нь буцаах талаар зохих арга хэмжээ авах;
- д) хөлөг онгоцны талаар томилогч улсын хууль тогтоомжид дурдсан аливаа мэдэгдэл буюу баримт бичгийг хүлээн авах, үйлдэх, гэрчлэх.

2. Хэрэв хүлээн авагч улсын хуулиар зөвшөөрсөн бол консулын албан тушаалтан нь хөлөг онгоцны дарга буюу багийн гишүүнийг хүлээн авагч улсын шүүх болон засаг захиргааны байгууллагуудтай харилцахад нь хамт очих, туслалцаа үзүүлэх, шаардлага гарвал хэлмэрчлэх эрхтэй.

45-р зүйл

1. Хэрэв хүлээн авагч улсын шүүх болон засаг захиргааны байгууллагууд томилогч улсын хөлөг онгоцон дээр албадагын чанартай буюу байцаан шалгах арга хэмжээ авах шаардлагатай бол тэр тухайгаа консулын зохих албан тушаалтанд мэдэгдэнэ. Хойшлуулж болшгүй маш яаралтай тохиолдлоос бусад үед хүлээн авагч улсын шүүх болон засаг захиргааны байгууллагууд дээрх арга хэмжээг авахдаа консулын албан тушаалтан буюу түүний төлөөлөгчийг байлцуулах хүрэлцээтэй цаг хугацааны өмнө мэдэгдэх ёстой. Хэрэв консулын албан тушаалтан буюу түүний төлөөлөгч биеэр байлцаагүй бол түүний хүсэлтээр хүлээн авагч улсын зохих эрх бүхий байгууллага болсон хэрэг явдлын тухай дэлгэрэнгүй мэдээллийг хийнэ.

2. Хөлөг онгоцны дарга буюу багийн гишүүнийг уг усан боомтын районы эрх бүхий байгууллага эх газар дээр байцаах бол энэхүү зүйлийн 1-ийн заалтыг баримтлана.

3. Гэвч энэхүү зүйлийн заалтууд нь гаалийн болон зам явах баримт бичиг, ариун цэврийн ердийн үзлэг шалгалт, тэрчлэн хөлөг онгоцны даргын хүсэлтээр буюу түүний зөвшөөрлөөр хийх аливаа арга хэмжээнд үл хамаарна.

46-р зүйл

1. Томилогч улсын хөлөг онгоц хүлээн авагч улсын нутаг дэвсгэр дээр сүйрэх, газардах, эрэгт хаягдах буюу гэмтэх, томилогч улсын буюу түүний иргэний өмч бөгөөд гуравдахь улсын сүйрсэн хөлөг онгоцны ачааны хэсэг нь болох эд юмс хүлээн авагч улсын эрэг, эргийн орчмоос олдсон буюу түүний усан боомтод хүргэгдсэнийг мэдвэл хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага аль болох түргэн хугацаанд энэ тухай томилогч улсын консулын албан тушаалтанд мэдэгдэнэ. Тэрчлэн хүлээн авагч улсын зохих байгууллага хөлөг онгоц, түүн дээр байгаа хүмүүс, ачаа болон бусад өмч хөрөнгө, тэр хөлөг онгоцноос салсан ачааны болон онгоцны хэсгийг аварч хамгаалах талаар авсан арга хэмжээнийхээ тухай консулын албан тушаалтанд мэдэгдэнэ.

2. Консулын албан тушаалтан нь хөлөг онгоц, түүний зорчигчид, багийн гишүүдэд аливаа туслалцаа үзүүлж болох бөгөөд үүний тулд хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагаас туслалцаа хүсч болно. Консулын албан тушаалтан нь энэхүү зүйлийн 1-д заасан зүйлээс гадна хөлөг онгоцонд засвар хийхтэй холбогдсон арга хэмжээ авах, түүнчлэн хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагад дээрх арга хэмжээг авах, авч буй арга хэмжээгээ үргэлжлүүлэх талаар хүсэлт тавьж болно.

3. а) Хөлөг онгоц буюу түүнд хамаарах аливаа эд юмс хүлээн авагч улсын эрэг буюу түүний орчмоос олдсон, эсвэл усан боомтод хүргэгдээд хөлөг онгоцны дарга, хөлөг онгоц, эд юмсын эзэн, түүний төлөөлөгч буюу даатгуулсан этгээдийн алин ч уг хөлөг онгоц, эд юмсыг хадгалан хамгаалж, захиран зарцуулж чадахгүйд хүрвэл консулын албан тушаалтан нь тэр хөлөг онгоц, эд юмсын эзнийг төлөөлөн шаардагдах арга хэмжээг авах эрхтэйд тооцогдоно.

б) «а»-гийн заалт нь хөлөг онгоцон дээр байсан томилогч улсын иргэний өмч, эд юмст нэгэн адил хамаарна.

4. а) Хөлөг онгоц, түүний ачаа, тоног төхөөрөмж, эд анги, нөөц буюу бусад зүйлүүд нь хүлээн авагч улсаас хэрэглэх, ашиглахад зориулагдаагүй бол оруулахтай холбогдсон аливаа татвараас чөлөөлөгдөнө.

б) 4-ийн «а»-гийн заалт нь эд юмс түр агуулах тухай хүлээн авагч улсын хууль дүрэмд үл харшилна.

5. Хэрэв гуравдахь улсын сүйрэлд орсон хөлөг онгоцны ачааны хэсэг болох эд юмс томилогч улсын иргэний өмч бөгөөд хүлээн авагч улсын эрэг буюу эрэг орчмоос олдсон, эсвэл түүний боомтод хүргэгдээд хөлөг онгоцны дарга, хөлөг онгоц, эд юмсын эзэн, түүний төлөөлөгч буюу даатгуулсан этгээдийн алин ч уг хөлөг онгоц, эд юмсыг хадгалан хамгаалж, захиран зарцуулж чадахгүйд хүрвэл консулын албан тушаалтан тэр хөлөг онгоц, эд юмсын эзнийг төлөөлөн шаардагдах арга хэмжээг авах эрхтэйд тооцогдоно.

47-р зүйл

Энэхүү Конвенцийн 43–46-р зүйлийн заалтууд иргэний агаарын тээврийн нисэх онгоцонд зохих хэмжээгээр нэгэн адил хэрэглэгдэнэ.

V ХЭСЭГ

Төгсгөлийн заалт

48-р зүйл

1. Энэхүү Конвенц нь аль болох түргэн батлагдах бөгөөд батламж жуух бичгүүдийг Улаанбаатар хотноо солилцсоноос хойш гуч дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Конвенцийг таван жилийн хугацаагаар байгуулав. Хэрэв Хэлэлцэн Тохирогч Эрхэм хоёр Этгээдийн аль нэг нь уг Конвенцийн хугацааг дуусахаас зургаан сарын өмнө Конвенцийг цуцлах тухайгаа эс мэдэгдвэл Хэлэлцэн Тохирогч аль нэг Этгээд нь уг Конвенцийг цуцлах тухайгаа Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээддээ мэдэгдэх хүртэл хүчинтэй байх бөгөөд ийнхүү мэдэгдсэнээс хойш зургаан сарын дараа хүчингүй болно.

Дээр дурдсаныг нотолж бүрэн эрхт төлөөлөгчид энэхүү Конвенцид гарын үсэг зурж, тамга дарав.

In witness whereof the respective Plenipotentiaries have signed this Convention and affixed thereto their seals.

Энэхүү Конвенцийг 1975 оны арван нэгдүгээр сарын 21-ний өдөр Лондон хотноо монгол, англи хэл дээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх хувь тус бүр нэгэн адил хүчинтэй болно.

Done in duplicate at London this 21st day of November, 1975, in the Mongolian and English languages, both texts being equally authoritative.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн өмнөөс:

For the Praesidium of the Great People's Khural of the Mongolian People's Republic:

Британийн Хатан Хааны өмнөөс: For Her Britannic Majesty:

*Coronouy - Roberts of
Cameron & Ogden.*